



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
ЯАМ



АЗИЙН
ХӨГЖЛИЙН
БАНК

МОН3787/3788: ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
“МАНДАЛТ КОНСТРАКШН” ХХК

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БУЙ
“ЧИНГИС ХААН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2025 он



MON3787/3788: ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БУЙ
“ЧИНГИС ХААН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 546803/

ХЯНАСАН: БОАЖЯ-ны ХБОБНГ-ын мэргэжилтэн

.....

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“Мандалт Констракшн” ХХК –ЗАХИРАЛ



Улаанбаатар
2025 он

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Удиртгал	3
1.2 Төслийн зорилго	3
1.3 Төслийн ач холбогдол	3
1.4 Ерөнхий төлөвлөлтийн концепци онцлог шинж.....	3
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	7
2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	7
2.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт.....	9
2.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	9
2.4 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	9
2.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	11
2.6 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	15
2.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	16

ХАВСРАЛТ ЗУРГИЙН ЖАГСААЛТ:

- Хавсралт зураг 1. Барилгын хог хаягдлыг хог хаягдлын нэгдсэн цэгт нийлүүлэх ажилын явц*
Хавсралт зураг 2. Хэт чанга дуут дохио ашиглахгүй байх анхааруулах тэмдэглэгээ байршуулсан
Хавсралт зураг 4. Тээврийн замын чиглэл заасан тэмдэглэгээнүүд
Хавсралт зураг 3. Үржил шимт хөрс хуулалт хадгалалт
Хавсралт зураг 5. Элс болон дайрганы карьерийн нөхөн сэргээлт
Хавсралт зураг 6. MNS5924:2015 стандартад нийцсэн нойлын суурилуулалт болон ашиглалт
Хавсралт зураг 7. Хог хаягдлыг ангилан ялгах савнууд байршуулсан
Хавсралт зураг 8. Агаарын чанарын хэмжилт дээжлэлтийн явц
Хавсралт зураг 9. Гадаргын болон гүний усны мониторинг судалгаа
Хавсралт зураг 10. Хөрсөн бүрхэвчийн мониторинг судалгаа
Хавсралт зураг 11. Агаарын чанарын хэмжилт дээжлэлтийн явц (III улирал)
Хавсралт зураг 12. Гадаргын болон гүний усны судалгаа (III улирал)
Хавсралт зураг 13. Хөрсөн бүрхэвчийн судалгааны явц (III улирал)
Хавсралт зураг 15. 113 модны нөхөн тарилт буюу 0.5 га 1200 ш тарьц ойжуулалтын ажил

ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Хавсралт материал 1. Хог хаягдал нийлүүлэх гэрээ*
Хавсралт материал 2. Археологийн хайгуул судалгааны ажилын дүгнэлт
Хавсралт материал 3. Агаарын чанарын шинжилгээний дүнгүүд
Хавсралт материал 4. Гадаргын болон гүний усны шинжилгээний дүнгүүд
Хавсралт материал 5. Хөрсний шинжилгээний дүнгүүд
Хавсралт материал 6. Агаарын чанарын шинжилгээний дүнгүүд (III улирал)
Хавсралт материал 7. Гадаргын болон гүний усны шинжилгээний дүнгүүд (III улирлын)
Хавсралт материал 8. Хөрсний дээжний шинжилгээний дүнгүүд (III улирлын)
Хавсралт материал 9. Төсөл хэрэгжих сум орон нутгийн иргэд болон удирдлагуудад төслийн талаарх мэдээллийг хүргэсэн тухай ажлын тайлан
Хавсралт материал 10. Төслийн бүтээн байгуулалтын үед нөлөөлөлд өртсөн айл өрхүүдтэй уулзаж санал хүсэлт аван зөвшилцөлд хүрсэн тухай ажлын тайлан
Хавсралт материал 11. сумын иргэд, удирдлага нарт төслийн гүйцэтгэл хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.
Хавсралт материал 12. Ойжуулалт хийсэн талаарх хамтран ажилласан “Хөл булаг трейд” ХХК-ний албан бичиг.
Хавсралт материал 13. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгсөн акт

БҮЛЭГ 1. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Удиртгал

Азийн хөгжлийн банкны санхүүжилттай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны захиалгаар хийгдэж буй “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл” нь Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газар, (ХУТХГ) болон Онон-Балжийн байгалийн цогцолборт газар (ОББЦГ)-т үндэсний жишиг зорин очих газрыг бий болгохыг зорьж байна.

1.2 Төслийн зорилго

Монголын Эзэнт гүрнийг үүсгэн байгуулагч, монгол үндэстний эв нэгдэл, сэргэн мандлыг дэлхий дахинаа тунхаглан зарласан аугаа их Чингис хааны эрдэм билэг, суу заль, энэрэхүйн ёс, хосгүй авьяас чадварыг дэлхий дахинд үнэн зөвөөр таниулах.

1.3 Төслийн ач холбогдол

Эзэн Чингис хааны түүхэн гавьяаг олон улсад үнэн зөвөөр таниулах, Монголын Эзэнт гүрэн, Алтан ургийн хаадын түүхийг өгүүлэх, төрт ёсны өв уламжлалыг таниулах, сурталчлахад цогцолборын түүхэн ач холбогдол оршино.


1.4 Ерөнхий төлөвлөлтийн концепци онцлог шинж

Ерөнхий төлөвлөгөөний концепцийг Онон-Балжийн голын хөндийд хамрагдаж байгаа үзэсгэлэнт байгаль болон талбайн зүүн хэсэгт урсах голын хөндий зэрэг байгалийн тогтцыг байгаа байдлаар нь хадгалан үлдээх, ирсэн зочид жуулчдад аливаа том хэмжээний барилга байгууламжийг үзүүлэх бус түүхэн дурсгалт газрын онгон тагшин газрыг байгаагаар нь үзүүлэхэд гол зорилгоо болгосон.

Дэлүүн болдог, Эрчист овоо, Хажуу булаг гэсэн гол түүхэн дурсгалт газруудыг Мэдээллийн төв болон Бортолгойд шинээр баригдах Тэнгэрийн Орд зэрэг байгууламжуудтай холбоо үүсгэн тэдгээрийг явган болон цахилгаан хөсгийн замаар холбож, мөн төлөвлөлтийн хилийн баруун талын нарсан ой дотор жуулчдын явган зугаалга хийх ердийн замтай холбосон болно.

Гадаад дотоодын жуулчдын хамгийн түрүүнд ирэх газар нь мэдээллийн төвийн хажууд байрлах автомашины зогсоол байх ба тэдгээр автомашинууд цогцолборын эдэлбэр газрын хүрээн дотор зорчих боломж хаалттай байна. Нийт гол болон зүүн, баруун гэсэн 3 нэвтрэх хэсэгтэй байхаар төлөвлөсөн.

Сумын төвийн хил хязгаарт ойрхон урд болон зүүн урд хэсэгт бафер бүс буюу хамгаалалтын бүсийг хамгаалалтад авахаар тооцоолсон. Дээрх төлөвлөлтийн зурган дээр үзүүлсэнчлэн явган болон цахилгаан автомашины замын дагуу ариун цэврийн болон амрах байгууламжуудыг давталттайгаар төлөвлөсөн болно.



Зураг 1. Ерөнхий төлөвлөлт

Архитектур төлөвлөлтийн шийдэл. Нийт ерөнхий төлөвлөгөөний талбайн хэмжээ 389 га

Хүснэгт 1. Ерөнхий төлөвлөгөөний бүрдэл, гүйцэтгэлийн хувь

№	Ерөнхий төлөвлөгөөний бүрдэл	Гүйцэтгэлийн хувь
1	Мэдээллийн төвийн барилга	80
2	Ариун цэврийн байгууламж-2ш	90
3	Мэдээллийн төвийн арын авто зогсоол	90
4	Хажуу булгийн тохижилт	50
5	Эвент талбайн тохижилт	50
6	Дэлүүн болдгийн амрах талбайн тохижилт	60
7	Дэлүүн болдог хөшөөний тохижилт	60
8	Эрчист овоо хөшөөний тохижилт	50
9	Нисдэг тэрэгний зогсоолын тохижилт	50
10	Амрах хэсгийн тохижилт / 3 байршилд	50



Зураг 3. Мэдээллийн төвийн барилгын ажлын явц



Зураг 2. Авто зогсоолын бүтээн байгуулалт



Зураг 4.Хажуу булгийн тохижилтын ажилын явц



Зураг 5. Сумын төвөөс мэдээллийн төв хүртлэх 1.5 км авто замын ажлын бүтээн байгуулалт

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн тухай	тайлбар
1. АГААРЫН ЧАНАР				
Тоос босох угаарын хийн бохирдол үүсэх, физик бохирдол буюу дуу шуугиан үүсэх	Барилгын хог хаягдлыг төслийн талбайн орчимд цуглуулалгүйгээр төвлөрсөн хогийн цэгт зайлуулах	Барилга байгууламж шинээр барихад 1м ² талбайгаас 0.013 тн хог хаягдал гарахаар заасан байдаг 4522.94м ² барилгажих талбайгаас нийт 58.79 тн хог хаягдал үүсэх бөгөөд хог хаягдлын цэгт нийлүүлэх	Барилгын хог хаягдлыг тухай бүр ачиж, хог хаягдлын цэгт нийлүүлсэн хог хаягдлын гэрээг / хавсралт материал 1/ . Хог хаягдлын ачилт тээвэрлэлтийн фотог / хавсралт зураг 1/ .	-
	Хэт чанга дуут дохио ашиглахгүй байх анхааруулах зөвлөмж техник хэрэгсэл бүрт байршуулах	Барилгын талбайд ажиллах техник хэрэгслүүдэд	Талбайд ажиллаж буй техник бүрт жолоочын хаалган талд нааж байршуулсан / хавсралт зураг 2/ .	
	Барилгын материал тээвэрлэх үед олон салаа шороон зам гаргахгүй байх чиглэл заасан тэмдэглэгээ байршуулах	Замын маршрут дагуу эргэлт болон зам салах цэг бүрт	Барилгын ажлын талбай болон тээврийн зам дагуу анхааруулах болон чиглэл заасан тэмдэглэгээнүүд байршуулсан / хавсралт зураг 3/ .	
2.УСАН ОРЧИН, ГОЛДИРОЛ, ЧАНАР				

Усны нөөц багасах, бохирдол	Ажилчдын унд ахуйн худгийг тоолууржуулах, эрүүл ахуйн бүс тогтоож хамгаалах	-эрүүл ахуйн бүс тогтоож хамгаалах байр барих -Худагт электрон тоолуур суурилуулах -усны төлбөр төлөх	Төслийн талбайд 3 гүний худаг байгаагаас 2 нь нөөцөд 1-г унд ахуйн хэрэгцээнд ашиглаж байна.	Одоогоор унд ахуйн хэрэглээнд ус ашиглаж байгаа тул тоолууржуулж тоноглогдоогүй байна.
	Хажуу булгийн тохижилт хийх	Булгийн тохижилт нь 260x248 хэмжээтэй газрыг хамарсан амралт зугаалах, идэвхтэй ногоон байгууламж бүхий талбай	Хажуу булгийн тохижилтын ажлын явц 50%-тай байна. Тохижилтын фотог /зураг 4/.	
Усны голдирол өөрчлөгдөх	Хажуу булгийн урсац болон Баянбулаг голын усны хаялгын дээгүүр металл гүүр барихаар төлөвлөсөн байна	Мэдээллийн төвөөс тэнгэрийн орд орох чиглэлд хажуу булгийн урсаж хөндлөн огтлон гарах тул тэр хэсэгт гүүр барих Дэлүүн болдог амрах газарт очих чиглэлд Баянбулаг голыг хөндлөн огтлох тул мөн гүүрэн байгууламж барина	Төслийн бүтээн байгуулалтын ажил явагдаж байгаа бөгөөд одоогоор гүүрийн ажил хийгдээгүй байна.	
3. ГАЗРЫН ГАДАРГА, ХҮРСЭН БҮРХЭВЧ				
Хөрсөн бүрхэвч устах Хөрсний бохирдол бий болох	Төлөвлөлтөд өртөх талбайн үржил шимт хөрсийг хадгалах	Төслийн төлөвлөлтөөр 4522.9 м ² талбай бариллагжих бөгөөд суурь ухалтанд өртөх тул үржил шимт хөрсийг хуулж хадгалан орчны тохижилт ногоон байгууламжид ашиглах	Мэдээллийн төвийн барилгын ажлын үед шимт хөрсийг хуулж хадгалсан байна /Хавсралт зураг 4/.	
	Бүтээн байгуулалтын үйл ажиллагааны үед эвдэрсэн, халцгайрсан газруудыг нөхөн сэргээх	Төлөвлөлтөөр шууд нөлөөлөлд өртөх газар байгаа хэдий ч дам нөлөөлөлд өртөх газруудыг нөхөн сэргээх шаардлагатай	Бүтээн байгуулалтанд ашиглаж буй түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглагдсан зарим талбайг хааж нөхөн сэргээсэн /Хавсралт зураг 5/. /Хавсралт материал 13./	

2.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэрэгжүүлсэн
1	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт	Нийт 4 хэсэг 905 м ² талбайд зүлэг тарисан байна	Төслийн талбайн зогсоолуудын жижиг арлууд дээр ногоон байгууламж буюу зүлэгжүүлэлт хийгдсэн, Соёолж компани орос улсаас оруулж ирсэн “red fescue”- герман сортын үрийг. /Хавсралт зураг 14/
2	Ойжуулалт	Ойн тухай хуулын дагуу 113 модны нөхөн тарилт буюу 0.5 га талбайд мод үржүүлгийн газарт үрээр тарьж ургуулсан нарс модны 2 настай 1200ш тарьцаар ойжуулалтын ажлыг стандарт, нормын дагуу тус сумын Хөл булаг трейд ХХК ойн мэргэжлийн байгуулгаар “Онон балжын байгалын цогцолбор газар”-т тарисан /Хавсралт зураг 15/, Хавсралт материал 12	

2.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн
1	Хажуу булгийн ойролцоох соёлын өвийг хамгаалах	Мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч хамтран ажиллана	“Мандалт констракшн”ХХК-н захиалгаар шинжлэх ухааны академи Археологийн хүрээлэнгийн судалгааны баг төслийн талбайд хайгуул судалгаа хийсэн байна /Хавсралт материал 2/.

2.4 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлсэн
1	Ахуйн	Ахуйн шингэн хог хаягдал	4.5 м ³ багтаамжтай эко нойл (соруулдаг)	<i>MNS5924:2015</i> “Нүхэн жорлон, угаадасны нүхний техникийн шаардлага”-д нийцсэн, байгальд ээлтэй арга хэлбэрээр ариун

				цэврийн байгууламжийг шийдвэрлэсэн /хавсралт зураг 6/.
		хог хаягдлыг ангилан ялгах сав	Төмөр, хуванцар,шил, цаасан хог хаягдалыг тус тусд нь хадгалж 2 догч түүхий эд авах цэгт нийлүүлэх	Хог хаягдлыг ангилан ялгах савнуудыг шаардлагатай газруудад байршуулсан /хавсралт зураг 7/.
2	Барилгын	хог хаягдлын гэрээний дагуу тогтмол хугацаанд ачуулж байх	Гэрээт ХХК-аар тээвэрлүүлэн хог хаягдлын цэгт нийлүүлнэ	Хог хаягдлын гэрээг байгуулан нэгдсэн цэгт хүргэж байна

2.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хяналт-шинжилгээ хийсэн үзүүлэлтүүд	Дээж авсан байршлууд	Лабораторийн шинжилгээний үр дүн
1. АГААРЫН ЧАНАР		
<p>Нийт тоос /TSP/, азотын давхар исэл SO₂, хүхэрлэг хий NO₂, дуу чимээ дБ(А)</p>	<p>2025 оны 6 сарын 8 нд буюу II улиралд,</p> <p>Агаар-1. N 49.040724 E111.627471 Мэдээллийн төв болон авто зогсоолын ойролцоо</p> <p>Агаар-2. N 49.0562919 E111.61080226- Тэнгэрийн орд</p> <p>Агаар-3. N49.05632274 E111.6107551 Дэлүүн болдог амрах газар</p> <p>Агаар-4. N49.05088918 E111.63955558 хажуу булаг болон эвент талбайн голд</p> <p>Агаар-5. N49.0409421 E111.62558596 Автомашинны зогсоол</p> <p>Агаар-6. N49.05088918 E111.63955558 ЧХАЖЦ хүрэх шороон зам дагуу</p>	<p>Тоосжилт: Төслийн төлөвлөлт болон бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан нийт 6 цэгт хэмжилт хийхэд автомашины зогсоол хэсэгт тоосны тархалт MNS 4585:2025 Агаарын чанарын стандарт хэмжээнээс давсан байх ба бусад хэсгүүд стандарт хэмжээнд байна.</p> <p>Шуугиан: Шуугианы хэмжилтийн 3 цэг дээр стандарт хэмжээнээс давсан үзүүлэлттэй байх ба энэ нь машин техникийн зорчих хөдөлгөөн болон барилгын ажлын явцтай шууд хамааралтай байна. Барилгын ажил явагдаагүй талбайд дуу чимээ байгалийн нийцээр стандарт хэмжээнд байна.</p> <p>Агаарын бохирдол SO₂, NO₂. Хэмжилтийн дүнгээр Азотын давхар исэл болон хүхэрлэг хий Монгол улсын агаарын чанарын стандарт MNS4585:2025-д заасан гадаад орчны агаар дахь азотын давхар ислийн нэг удаагийн /20 минут/ зөвшөөрөгдөх хэмжээнд, стандартаас нэлээд доогуур байна.</p> <p>Хэмжилт, дээжлэлтийн фотог /хавсралт зураг 8/, шинжилгээний үр дүнг /хавсралт материал 3/.</p>

	<p>2025 оны 9 сарын 7 нд буюу III улиралд</p> <p>Агаар-1. N 49°02'27.2" E 111°37'31.3" Мэдээллийн төв</p> <p>Агаар-2. N 49°02'34.2" E 111°37'29.2" - Элсний карьер</p> <p>Агаар-3. N 49°03'14.9" E 111°37'13.4" Дэлүүн болдог амрах газар</p> <p>Агаар-4. N 49°03'14.9" E 111°37'13.4" хажуу булаг болон авто зогсоол тохижилт</p> <p>Агаар-5. N 49°02'25.2" E 111°37'39.7" Авто зогсоол мэдээллийн төвийн дунд</p>	<p>Тоосжилт, шуугиан: Төслийн төлөвлөлт болон бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан нийт 5 цэгт хэмжилт хийхэд MNS 4585:2025 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага стандарт хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.</p> <p>Агаарын бохирдол SO₂, NO₂. Хэмжилтийн дүнгээр Азотын давхар исэл болон хүхэрлэг хий Монгол улсын агаарын чанарын стандарт MNS4585:2025-д заасан гадаад орчны агаар дахь азотын давхар ислийн нэг удаагийн /20 минут/ зөвшөөрөгдөх хэмжээнд, стандартаас нэлээд доогуур байна.</p> <p>Хэмжилт, дээжлэлтийн фотог /хавсралт зураг 11/, шинжилгээний үр дүнг /хавсралт материал 6/.</p>
<p>2. ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС</p>		
<p>Усны ерөнхий хими: ерөнхий хатуулаг, урвалын орчин /рН/ Исэлдэх чанар, Тунгалагшил, Өнгө, Үнэр, Амт, Тунадас Анион /Cl⁻, SO₄⁻, NO₂⁻, NO₃⁻, CO₃⁻, HCO₃⁻/ Катион /Na⁺ + K⁺, Ca⁺⁺, Mg⁺⁺, NH₄⁺, Fe⁺⁺, Fe⁺⁺⁺</p>	<p>2025 оны 6 сарын 8 нд буюу II улиралд,</p> <p>Ус-1. N 49°02'29.4" E 111°37'30.0" –Гүний худаг-1. Ус-2. N 49°02'54.7" E 111°37'11.7"-Гүний худаг-2 Ус-3 N 49°03'02.3" E 111°38'02.4"- Баянбулгийн гол Ус-4 N 49°02'46.0" E 111°36'51.9"-Хажуу булаг</p>	<p>Худаг 1, 2 Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018” стандартын шаардлага хангаж байна. Ундны усны стандарт хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй.</p> <p>Хажуу булаг: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, холимог бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүд нь “Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586:1198” стандартын шаардлага хангаж байна.</p> <p>Баянбулаг гол: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна.</p>

	<p>2025 оны 9 сарын 7 нд буюу III улиралд Ус-1. N 49°02'29.5" E 111°37'30.2" – Ажилчдын худаг. Ус-2. N 49°03'02.2" E 111°38'01.9"- Баянбулгийн гол Ус-3 N 49°02'46.2" E 111°36'51.8"-Хажуу булаг</p>	<p>Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүд нь “Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586:1198” стандартын шаардлага хангаж байна.</p> <p>Хэмжилт, дээжлэлтийн фотог /хавсралт зураг 9/, шинжилгээний үр дүнг /хавсралт материал 4/.</p> <p>Баянбулаг гол: Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын ангийн, магнийн бүлгийн, II-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, дунд зэрэг эрдэсжилттэй, бага хатуулагтай ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүд нь “Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586:1198” стандартын шаардлагыг нитратаас бусад үзүүлэлт хангаж байна.</p> <p>Хажуу булаг: Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, магнийн бүлэг, II төрлийн цэнгэг буюу дунд зэрэг эрдэсжилттэй, бага хатуулагтай ус. Өнгө, үнэргүй, булингаргүй тунгалаг.</p> <p>Худаг: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын анги, магнийн бүлэг, II-р төрлийн, цэнгэг буюу дунд зэрэг эрдэсжилттэй, бага хатуулагтай ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018” стандартын шаардлага хангаж байна. Ундны усны стандарт хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй.</p> <p>Хэмжилт, дээжлэлтийн фотог /хавсралт зураг 12/, шинжилгээний үр дүнг /хавсралт материал 7/.</p>
<p>3. ХӨРСӨН БҮРХЭВЧ</p>		

<p>Хөрсний хими, механик бүрэлдэхүүн, хүнд металл, эрүүл ахуй: pH, давс, цахилгаан дамжуулах чанар, ялзмаг, карбонат, шингээгдсэн сууриуд Ca, Mg, шим тэжээлийн элементүүд P₂O₅, K₂O, ширхэгийн бүрэлдэхүүн, Эрүүл ахуй, Хүнд металл- Ni, Cd,Pb,Cu,Zn, Cr</p>	<p>2025 оны 6 сарын 8 нд буюу II улиралд,</p> <p>Хөрс -1. N 49°02'24.7" E 111°37'29.2" Авто зогсоол мэдээллийн төвийн дунд Хөрс-2. N 49°03'03.1" E 111°38'22.1"- Дэлүүн болдог амралт Хөрс-3. N 49°03'22.5" E 111°36'38.7" Тэнгэрийн орд Хөрс-4. N 49°02'50.5" E 111°37'09.5" хажуу булаг болон эвент талбайн голд Хөрс-5. N 49°02'27.6" E 111°37'30.0" Ажилчдын нойлын ойролцоо</p> <p>2025 оны 9 сарын 7 нд буюу III улиралд,</p> <p>Хөрс -1. N 490225.2 E 1113739.7 мэдээллийн төв. Хөрс-2. N 490314.9 E 1113713.4 Элсний карьер Хөрс-3. N 490303.3 E 1113822.3 Дэлүүн болдог авто зогсоол тохижилт Хөрс-4. N 490246.0 E 1113656.1 хажуу булаг авто зогсоол тохижилт Хөрс-5. N 490225.5 E 1113727.3 Автозогсоол мэдээллийн төвийн дунд Хөрс-6. N 490227.8 E 1113728.6 Ажилчдын нойлын ойролцоо</p>	<p>Хөрсний механик бүрэлдэхүүн: Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход мэдээллийн төв, автозогсоолын ойролцоо хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хүндэвтэр хөрс байх бол бусад газарт элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөнгөн хөрс тархсан байна.</p> <p>Хөрсний химийн үзүүлэлт: Төслийн талбайд тархах уулын хар шороон хөрсний урвалын орчин (pH) саармагаас сул шүлтлэг буюу ургамал ургах таатай нөхцөлтэй, хөрсөнд хялбар уусах давсжилтгүй, карбонатын агууламжгүй, солилцох суурь дунд, шим тэжээлийн элемент фосфор бага, кали дунд, ялзмагийн агууламж хангалттай байна.</p> <p>Хөрсөн дэх зарим хүнд металл: Хөрсөн дэх зарим хүнд металлын шинжилгээгээр хром элсэнцэр хөрсөнд байх хэмжээнээс бага зэрэг давсан үзүүлэлттэй байх хэдий ч Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад хүлцэх, хортой болон аюултай агууламжаас доогуур буюу хөрс бохирдолгүй байна.</p> <p>Хөрсний эрүүл ахуй: Шинжилгээний дүнгээр гэдэсний савханцар илрэх хамгийн бага хэмжээ (колтитр) ≥ 0.01 буюу бага зэрэг бохирдолтой, агааргүйтэн нян илрэх хамгийн бага хэмжээ (перфрингенс титр) ≥ 0.1 буюу цэвэр, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян (салмонелла) илэрсэн буюу бага зэрэг бохирдолтой.</p> <p>Хэмжилт, дээжлэлтийн фотог /хавсралт зураг 10, хавсралт зураг 13/, шинжилгээний үр дүнг /хавсралт материал 5, 8/.</p>
--	--	---

--	--	--

2.6 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Хэрэгжилт
Төлөвлөлтийн бусаар газар эвдрэх	Бүтээн байгуулалтын үе шатанд байгаль орчны стандарт шаардлага баримтлах талаар сургалт зохион байгуулах (ажилчдад)	Сургалтын арга хэмжээг улирал бүр шаардлагатай тохиолдолд тухай бүр авч хэрэгжүүлсэн
Техник хэрэгсэл эвдрэх тос масло асгарах хөрс бохирдох	Техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, гэнэтийн аюул ослоос (гал, түймэр, үер ус) урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдлын арга хэмжээний сургалт зохион байгуулах	
Хог хаягдал ил задгай хаях орчныг бохирдуулах	Төслийн хэтийн төлөвлөлтөөр гадаад дотоодын олон жуулчид ирэх учир Дадал сумын иргэдийг хог хаягдлаа ангилан ялгах хэвшилд сургаж сургалтыг зохион байгуулна	Төслийн санхүүжилттэй холбоотойгоор сургалтын арга хэмжээ хойшлогдсон.
Малчин өрх айлуудын гол түшиц болсон бэлчээр доройтох	Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох сургалт зохион байгуулна	

2.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Хэрэгжүүлсэн тухай
Төслийн нөлөөллийн бүсийн айл өрхүүдийг төслийн талаарх мэдээллээр хангах, санал гомдол хүлээн авч шийдвэрлэх Төслийн үйл ажиллагаагаар нөлөөлөлд өртөх айлуудтай ярилцан тохиролцох, зөвшилцөлд хүрэх	Төслийн нөлөөллийн бүсийн айл өрхүүдэд төслийн талаарх мэдээллийг хүргэж уулзаж ярилцана.	Олон нийтийн оролцоог хангах хэрэгжиж буй төслийн талаар мэдээлэл хүргэж санал хүсэлт авч тухай бүр шийдвэрлэж ажилласан. /Хавсралт 9/
	Зам, зогсоол, цахилгаан дамжуулах шугамын барилга угсралтыг хийх үед ажлын талбайд өртсөн айл өрхүүдтэй уулзаж, зөвшилцөх.	Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртсөн айлуудтай ярилцан тохиролцож, зөвшилцөлд хүрсэн ажлын тайлан. Нөлөөлд өртсөн айл өрхүүд гомдолгүй талаарх албан бичиг /Хавсралт 10/
Төсөл хэрэгжих сумын ард иргэдэд төслийн талаарх мэдээлэл хүргэж хамтран ажиллана	Төслийн танилцуулга хийж санал хүсэлтийг хүлээн авч ажиллана.	2025 оны 11 сарын 27-ны өдөр сумын иргэд, удирдлага нарт төслийн танилцуулга хэлэлцүүлгэ зохион байгуулсан /хавсралт материал 11/
Аймгийн Байгаль орчны газар	Тухайн жилийн БОМТ-г дүгнүүлэх, биелэлтийн тайлан хүргүүлэх	Тайланг хүргүүлж байна
УАӨЯ-нд БОМТ биелэлтийн тайланг хүргүүлж хянуулна	Тухайн жилийн БОМТ-г дүгнүүлэн, биелэлтийн тайланг илгээж хянуулах	БОМТ-ний биелэлтийн тайланг илгээж, хянуулж байна.

Хавсралт материал 1. Хог хаягдал нийлүүлэх гэрээ

ХОГ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2025 оны 03 сарын 01 -ны өдөр

Баян-Овоо баг

Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү гэрээний гол зорилго нь Баян-Овоо багийн нутаг дэвсгэр дэх Мандалт констракшн ХХК -ны хог хаягдлыг тээвэрлэх, үүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны харилцааг зохицуулахад оршино.

Нэг талаас Баян-Овоо баг -ыг төлөөлж С.Хуучир /цаашид гүйцэтгэгч гэх/ нөгөө талаас Мандалт констракшн ХХК-ийг төлөөлж /цаашид захиалагч гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хэлэлцэж байгуулав.

Энэхүү гэрээний төлбөр тооцооны харилцаанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 07 сарын 07-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан үнийн тарифыг дагаж мөрдөнө.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

- 2.1 Захиалагч нь ахуйн болон хуурай хог хаягдлыг ачуулсан төлбөрөө тогтоосон тарифын дагуу цаг хугацаанд нь төлж байх үүрэгтэй.
- 2.2 Захиалагч нь гарсан ахуйн болон хуурай хог хаягдлыг заасан хуваарийн дагуу тээвэрлүүлэх, тээвэрлэхийг шаардах эрхтэй.
- 2.3 Гүйцэтгэгчээс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа хугацаандаа хог тээвэрлээгүй тохиолдолд гэрээг цуцлах саналаа гаргах эрхтэй.
- 2.4 Захиалагч хог тээвэрлүүлсэн тухай бүрд жолоочийн тооцооны хуудсанд холбогдох тэмдэглэлийг хийж баталгаажуулна.
- 2.5 Захиалагч гарсан хог хаягдлыг зориулалтын уутанд хийж хогийн цэг, саванд түр хадгалах, эсвэл хог тээврийн машинд шууд ачуулах үүрэгтэй.
- 2.6 Захиалагч нь ямарч тохиолдолд гарсан хог хаягдлыг зориулалтын бус газарт болон ил задгай хаяхыг хориглоно.

2.7 Захиалагч нь сумаас зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээний ажилд идэвхитэй оролцох үүрэгтэй.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

3.1 Гүйцэтгэгч нь захиалагчаас гарсан ахуйн болон хуурай хог хаягдлыг заасан хуваарийн дагуу заасан хугацаанд саадгүй ачиж тээвэрлэх үүрэгтэй.

3.2 Барилгын болон хортой, тусгай хог хаягдлыг холбогдох журмын дагуу тээвэрлэнэ.

3.3 Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг нэхэмжлэх, заасан хугацаандаа төлөхийг шаардах эрхтэй.

3.4 Хог тээвэрлэлтийн хураамжийн нэхэмжлэхийг тухай бүр захиалагчид гаргаж өгөх үүрэгтэй.

3.5 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол илүү цагаар нэмэгдэл хүч зохион байгуулан ачих арга хэмжээг авна.

3.6 Тухайн байгууллагын төлбөрийн тооцоо хийгдээгүй тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэхгүй ба түүнээс гарсан асуудлыг "Дадал тохижилт" ОНӨААТҮГазар хариуцахгүй болно.

Дөрөв. Бусад

4.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарсанаар хүчин төгөлдөр болно.

4.2 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай бол талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

4.3 Талууд энэхүү гэрээг дангаараа цуцлах эрхгүй. Гэрээг цуцлах бол саналаа 14 хоногийн өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.

Гэрээ байгуулсан талууд

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Албан тушаал *А.А.А.*

Нэр *А.А.А.*

Утас *96967806*



Захиалагчийг төлөөлж:

Албан тушаал *Мөнхтүвшин*

Нэр *Мөнхтүвшин*

Утас *97050410*



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 02

Баян-Овоо

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн
хэмжээнд нэмэлт өөрчлөлт оруулж
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын хэмжээнд мөрдөгдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн жагсаалтанд 26 дугаар заалтыг нэмэлтээр оруулж хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хог хаягдлын үйлчилгээний хураамжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хураамжийг төвлөрүүлж, хог хаягдлын менежментийг сайжруулж хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Д.Мөнх-Од), хэрэгжилтийг хангуулж ажиллахыг сумын "Дадал тохижилт" ОНӨААТҮГ-ын захирал (С.Туяацэцэг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ОЮУНБААТАР


017000007

Сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдрийн 02 дугаар
тогтоолоор батлав.

Хог хаягдлын үйлчилгээний хураамж

№	Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Төлбөр /төг/
1	Галлагаатай орон сууц гэр хорооллын айл өрх	Нэг сарын төлбөр	10000
2	Гэр хороололд байрласан худалдааны цэг, дэлгүүр, ТҮЦ	Нэг сарын төлбөр	15000
3	Талх нарийн боов, зайрмаг, хиам, хэрчсэн гурил, оёдол, цайны газар, үсчин	Нэг сарын төлбөр	15000
5	Нийтийн хоол, гуанз, ресторан, барны газрын хог хаягдал	Нэг сарын төлбөр	15000
6	Төрийн болон төрийн бус байгууллагын хог хаягдал	Нэг сарын төлбөр	15000
7	Сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, амралт, сувилалын байгууллагын хог хаягдал	Нэг сурагчид ноогдох Цэцэрлэгийн 1 хүүхдэд ноогдох Эмнэлэг, амралт, сувилал ор тутмаар	100 100 7000
8	Зочид буудал	Нэг сарын төлбөр	15000
9	Мал амьтаны түүхий эд авдаг цэгүүд	Нэг сарын төлбөр	30000
10	Мал нядалгааны газар /бойны цэгүүд/	Нэг сарын төлбөр	80000
11	Халуун усны газар	Нэг сарын төлбөр	20000
12	Барлигын хог хаягдал	Нэг сарын төлбөр	20000
13	Нийтийн үзвэр, үйлчилгээний газрын хог хаягдал	Нэг сарын төлбөр	15000
14	Ердийн галлагаатай бага оврийн зуух тутмаас /9 сарын 15 наас 5 сарын 15/ хүртэл гэрээгээр	Нэг сарын төлбөр	50000
15	Шатахуун түгээх станц	Нэг сарын төлбөр	15000
16	Авто машин засвар үйлчилгээ, дугуй засвар, машин угаалгын газар	Нэг сарын төлбөр	15000
17	Зориулалтын бус газар зогсож, худалдааны үйл ажиллагаа явуулдаг иргэн /баяр наадмын үеэр барьсан үйлчилгээний гэр болон цэг орно/	Тухай бүр	20000
18	Том оврын уурын зуух тутмаас /09 дүгээр сарын 15 наас 05 дугаар сарын 15 ныг хүртэл/	Нэг сарын төлбөр	100000
19	Захиалгат хог хаягдал /их хэмжээний/	1 тн	20000
20	Хөрөө рамнууд	Нэг сараар төлбөр	15000
21	Хур хог	1тн	20000
22	Хөдөө болон малчин өрхүүд	Нэг сарын төлбөр	10000
23	Бохир соруулах	1 удаа	120000
24	50 Ковш /түлшний зардал орохгүй/	Өдрийн	250000

Хавсралт материал 2. Археологийн хайгуул судалгааны ажилын дүгнэлт



"МАНДАЛТКОНСТРАКШН" ХХК-Д

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**

ШУА-ийн хүрээлэнгүүдийн хөгжсөн 1 дүгээр байр.
Энхтайвны өрхөн чөлөө, 33 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13330
Утас: 45 28 64, 45 28 99. Факс: (976-11) 45 28 99.
Цахим шуудан: archaeology@mas.gov.mn

2023. 11.08 № 01/470

Ташай _____ -ны № _____ -Т

**Археологийн хайгуул судалгааны
ажил гүйцэтгэсэн тухай**

Монгол Улсын "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулийн 5-р бүлгийн 27-р зүйлийн 8-д *"Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна"* гэж заасны дагуу тус хүрээлэнгийн судалгааны баг "Мандалтконстракшн" ХХК-ийн хүсэлтээр Хэнтий аймгийн Дадал сумын нутагт байгуулах Чингис хааны аялал жуулчлалын цогцолборын бүтээн байгуулалтын талбайд археологийн хайгуул судалгааны ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 05-12-ныг дуустал хугацаанд хийж гүйцэтгэв.

Хайгуул судалгааны хүрээнд Чингис хааны аялал жуулчлалын цогцолборын бүтээн байгуулалтын талбайд болон түүний орчимд нийт 22 археологийн дурсгалыг илрүүлэн, бүртгэн баримтжуулсны дотор дундад зууны үед холбогдох боломжтой булш, оршуулгын дурсгал 19, тахил тайлгын байгууламж 2, эртний төмөрлөг боловсруулах үйлдвэрлэлийн газар 1 тус тус багтаж байна. Хайгуул судалгаагаар илэрсэн эртний булш, оршуулгын дурсгал болох 001-018 дугаартай дурсгалууд нь Их Яргайт уулын овооны орчимд, Чингис хааны аялал жуулчлалын цогцолборын бүтээн байгуулалтын талбайгаас 60-100 метр зайд оршино. Их Яргайт уулын археологийн дурсгалууд хэдийгээр бүтээн байгуулалтын талбайд ороогүй ч овоонд гардаг автозамын хажууд оршиж, зарим дурсгал (006-р дурсгал) авто замд дайрагдсан байгаа тул дурсгалын хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдалд онцгой анхаарах шаардлагатай байна. 019-021, 022 дугаартай дурсгалууд Чингис хааны аялал жуулчлалын цогцолборын бүтээн байгуулалтын талбайд Бор толгой болон Хажуу булгийн орчимд оршино.

Дээрх археологийн дурсгалууд Монголын эртний түүхэнд холбогдох түүх соёлын биет өвүүд бөгөөд хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдалд онцгой анхаарал хандуулж, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Монгол Улсын "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулийн дагуу археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлыг гүйцэтгүүлэх, ялангуяа Хажуу булагийн эртний төмөрлөг үйлдвэрлэлийн дурсгалт газрын судалгаа, хадгалалт хамгаалалт, ил музей, аялал жуулчлалын үнэ цэнтэй бүтээгдэхүүн болгох зэрэг олон талт ажлыг хамтран зохион байгуулах, дахин төлөвлөх зайлшгүй шаардлагатай хэмээн үзэж байна.

121070436

Мөн бүтээн байгуулалтын ажлын явцад газрын хөрсөн доор булагдаж дарагдсан түүх, соёлын дурсгал илэрч олдох боломжтой тул анхаарал болгоомжтой ажиллаж, ямар нэгэн дурсгал, олдвор илэрсэн тохиолдолд нэн даруй мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад мэдэгдэхийг зөвлөж байна.

Жич: Хайгуул судалгааны ажлын тайланг хавсралтаар хүргүүлэв.

ЗАХИРАЛ, ДОКТОР (Ph.D),
ДЭД ПРОФЕССОР



Г.ЭРЭГЗЭН

Хавсралт материал 3. Агаарын чанарын шинжилгээний дүнгүүд



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzi@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/A-476
 Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Дөрвөн Талст Экологи" ХХК
 Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
 Сорьцдын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
 Сорьц авсан огноо : 2025.06.08
 Сорьцдын тодорхойлолт : Хэнтий аймаг Дадал сум Баян-Овоо баг
 Чингис хаан АЖЛЦ мэдээллийн төвийн барилга
 Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
 MNS 0768:2019, CAЗ А07-2016
 Шинжилсэн огноо : 2025.06.18
 Хуудасны тоо : 1/1

Үр дүн :

№	Сорьц авсан цаг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос /TSP/	Дуу чимээ
							дБА
1	Барилга орчим	25/06/08	16.40	0.011	0.023	0.294	76
Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч :

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч:



Э.Оюунтуяа

Б.Алтантуяа



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzi@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/A-477
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Дөрвөн Талст Экологи" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2025.06.08
Сорьцын тодорхойлолт : Хэнтий аймаг Дадал сум Баян-Овоо баг
Эвэнт талбайн барилгын ажил хийгдэх талбай
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 6708,2019, CAZ A07-2010
Шинжилсэн огноо : 2025.06.18
Хуудасны тоо : 1/1

Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос /TSP/	Дуу чимээ
							дБА
1	Талбай орчим	25/06/08	17:15	0.012	0.039	0.360	68
Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч :

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч:



Э.Оюунтуяа

Б.Алтантуяа



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzi@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/A-478
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Дөрвөн Талст Экологи" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2025.06.08
Сорьцын тодорхойлолт : Хэнтий аймаг Дадал сум Баян-Овоо баг
Тэнгэрийн орд барилгын ажил хийгдэх талбай
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 6768:2019, CA3 A07-2016
Шинжилсэн огноо : 2025.06.18
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цаг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос (TSP)	Дуу чимээ
							дБА
1	Талбай орчим	25/06/08	18:00	0.009	0.052	0.083	40
Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч :

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч:



Э.Оюунтуяа

Б.Алтантуяа



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/A-479
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Дөрвөн Талст Экологи" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2025.06.08
Сорьцын тодорхойлолт : Хэнтий аймаг Дадал сум Баян-Овоо баг
Дэлүүн болдог амрах талбайн барилгын талбай
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 6768:2016, CA3 A07-2016
Шинжилсэн огноо : 2025.06.18
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цаг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос /TSP/	Дуу чимээ
					мг/м ³		ДБА
1		25/06/08	18:40	0.008	0.031	0.154	38
Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч :

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч:



Э.Оюунтуяа

Б.Алтантуяа



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztli@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/A-480
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Дөрвөн Талст Экологи" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2025.06.08
Сорьцын тодорхойлолт : Хэнтий аймаг Дадал сум Баян-Овоо баг
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 6768:2019, CA3 A07-2016
Шинжилсэн огноо : 2025.06.18
Хуудасны тоо : 1/1

Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хийг	Азотын давхар исэл		Дуу чимээ
					Нийт тоос /TSP/	ДБА	
1	Тээврийн зам дагуу	25/06/08	19:30	0.010	0.044	0.167	40
Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч :

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч:



Э.Оюунтуяа

Б.Алтантуяа



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzi@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/A-481
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Дөрвөн Талст Экологи" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агварын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2025.06.08
Сорьцын тодорхойлолт : Хэнтий аймаг Дадал сум Баян-Овоо баг
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 6768:2019, CA3 A07-2016
Шинжилсэн огноо : 2025.06.18
Хуудасны тоо : 1/1

Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл			Дуу чимээ
					Нийт тоос /TSP/	мг/м ³	ДБА	
1	Авто машины зогсоол	25/06/08	20:00	0.012	0.028	0.687	74	
Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60	

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч :

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч.



Э.Оюунтуяа

Б.Алтантуяа

Хавсралт материал 4. Гадаргын болон гүний усны шинжилгээний дүнгүүд



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2025 оны 06 сарын 09 өдөр
Шинжилгээ хийсэн: 2025 оны 06 сарын 16 өдөр
Сорьц авсан газрын нэр: Хэнтий аймаг, Дадал сум

Хажуу булаг

Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Мандалт Констракшн" ХХК

Солбицол: X= Гүн: м
Y= Ундарга: л/сек

Уст цэгийн төрөл ба дугаар: Булаг

Тодорхойлсон нь:

Анион	1дм ³ -д байгаа			Катион	1дм ³ -д байгаа		
	мг	мг-эқв	мг-эқв%		мг	мг-эқв	мг-эқв%
Cl ⁻	4.3	0.12	3.2	Na ⁺ +K ⁺	27.3	1.19	31.9
SO ₄ ⁻	18.0	0.38	10.1	Ca ⁺⁺	28.1	1.40	37.6
NO ₂ ⁻	0.01	0.00	0.0	Mg ⁺⁺	13.9	1.14	30.6
NO ₃ ⁻	2.0	0.03	0.9	NH ₄ ⁺	0.0	0.00	0.0
CO ₃ ⁻	12.0	0.40	10.7	Fe ⁺⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	170.8	2.80	75.1	Fe ⁺⁺⁺	0.0	0.00	0.0
Дүн	207.1	3.73	100.0	Дүн	69.2	3.73	100.0

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын
нийлбэр: 190.9 мг/дм³

Анион катионуудын
нийлбэр: 276.3 мг/дм³

Ерөнхий хатуулаг 2.54 мг-эқв/дм³

pH: 7.80

Исэлдэх чанар:

0.48 мг/дм³

Физик шинж чанар

Тунгалаг: 30 см

Өнгө: Өнгөгүй

Үнэр: Үгүй

Амт: +++

Тунадас: Үгүй

HCO₃ 75 SO₄²⁻ 10

Усны найрлагын томъёо: Mg_{0.28}

Ca²⁺ 38 Na⁺+K⁺ 32 Mg²⁺ 31

Дүгнэлт

Хавийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, халимог бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэцгэг, зөөлөн ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүд нь "Усан орчны чанарын үзүүлэлт МУС 4586:2024" стандартын шаардлага хэлгэж байна.

Жич: Энэхүү уст цэвэс сорьц өвх үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн харууцан гүйцэтгэсэн болно.

Шинжилгээ Гүйцэтгэсэн: Химич, ЭШДЭА: _____ Г. Гүрийнтүяа/
Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч _____ Д.Тэрэлт-Од/





ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
 ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
 УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2025 оны 06 сарын 09 өдөр
 Шинжилгээ хийсэн: 2025 оны 06 сарын 16 өдөр
 Сорьц авсан газрын нэр: Хэнтий аймаг, Дадал сум
 Баянбулаг гол

Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Мандалт Констракшн" ХХК

Солбицол: X= Гүн: м
 Y= Ундарга: л/сек

Уст цэгийн төрөл ба дугаар: Гол

Тодорхойлсон нь:

Анион	1дм ³ -д байгаа			Катион	1дм ³ -д байгаа		
	мг	мг-эқв	мг-эқв%		мг	мг-эқв	мг-эқв%
Cl ⁻	4.3	0.12	3.1	Na ⁺ +K ⁺	13.8	0.60	15.7
SO ₄ ⁻	8.0	0.17	4.4	Ca ⁺⁺	36.3	1.81	47.4
NO ₂ ⁻	0.00	0.00	0.0	Mg ⁺⁺	16.7	1.37	35.9
NO ₃ ⁻	2.0	0.03	0.8	NH ₄ ⁺	0.4	0.02	0.6
CO ₃ ⁻	0.0	0.00	0.0	Fe ⁺⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	213.5	3.50	91.6	Fe ⁺⁺⁺	0.3	0.02	0.4
Дүн	227.8	3.82	100.0	Дүн	67.4	3.82	100.0

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын
 нийлбэр: 188.5 мг/дм³

Анион катионуудын
 нийлбэр: 295.2 мг/дм³

Ерөнхий хатуулаг 3.18 мг-эқв/дм³

EC: 311 µS/cm

pH: 7.54

TDS: 171 ppm

Исэлдэх чанар: 4.80 мг/дм³

Физик шинж чанар

Тунгалаг: 28 см

Үнэр: үгүй

Тунадас: Үл мэдэг

Өнгө: Сул шаргал

Амт: ***

HCO₃ 92

Усны найрлагын томъёо: M_{0.29} Ca²⁺47 Mg²⁺36 Na⁺+K⁺16

Дүгнэлт

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэвэртэй, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн үлдсэн үзүүлэлтүүд нь "Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586:2024" стандартын шаардлага хангаж байна.

Жич: Энэхүү уст цагаж сорьц авах үйл ажиллагааг хийж байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

Шинжилгээ Гүйцэтгэсэн: Химич, ЭШДЭА: _____ /Г.Үүрийнтуяа/

Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч _____ /Д.Гэрэлт-Од/





ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
 ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
 УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2025 оны 06 сарын 09 өдөр
 Шинжилгээ хийсэн: 2025 оны 06 сарын 16 өдөр
 Сорьц авсан газрын нэр: Хэнтий аймаг, Дадал сум

Худаг №2

Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Мандалт Констракшн" ХХК

Солбицлол: X= Гүн: м
 Y= Ундарга: л/сек

Уст цэгийн төрөл ба дугаар: Худаг

Тодорхойлсон нь:

Анион	1дм ³ -д байгаа			Катион	1дм ³ -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%
Cl ⁻	9.9	0.28	10.0	Na ⁺ +K ⁺	10.2	0.44	15.8
SO ₄ ⁻	7.5	0.16	5.6	Ca ⁺⁺	28.9	1.44	51.2
NO ₂ ⁻	0.00	0.00	0.0	Mg ⁺⁺	11.3	0.93	33.1
NO ₃ ⁻	42.0	0.68	24.1	NH ₄ ⁺	0.0	0.00	0.0
CO ₃ ⁻	0.0	0.00	0.0	Fe ⁺⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	103.7	1.70	60.4	Fe ⁺⁺⁺	0.0	0.00	0.0
Дүн	163.1	2.81	100.0	Дүн	50.4	2.81	100.0

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын
 нийлбэр: 161.7 мг/дм³

Анион катионуудын
 нийлбэр: 213.5 мг/дм³

Ерөнхий хатуулаг 2.37 мг-экв/дм³

EC: 248 μS/cm

pH: 6.50

TDS: 136 ppm

Исэлдэх чанар: 0.48 мг/дм³

Физик шинж чанар

Тунгалаг: 30 см

Үнэр: үгүй

Тундас: Үгүй

Өнгө: Өнгөгүй

Амт: ***

HCO₃ 60 Cl 10

Усны найрлагын томъёо: M_{0.21} Ca²⁺ 51 Mg²⁺ 33 Na⁺+K⁺ 16

Дүгнэлт

Хөвөн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд цэвэртэй, зөөлөн ус байна. Шинжилсэн хөвөн үндсэн үзүүлэлтүүд нь "Ундны ус. Эрүүл ажуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNSO900:2018" стандартын шаардлага хангаж байна.

Мик: Энхүү уст цээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

Гүйцэтгэсэн: Химич, ЭШДЭА: _____ /Г. Үүрийнтуяа/

Шинжилгээ

Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч _____ /Д.Төрэлт-Од/





ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2025 оны 06 сарын 09 өдөр
Шинжилгээ хийсэн: 2025 оны 06 сарын 16 өдөр
Сорьц авсан газрын нэр: Хэнтий аймаг, Дадал сум

Худал

Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Мандалт Констракшн" ХХК

Солбицол: X=
Y=

Гүн: м
Ундарга: л/сек

Уст цэгийн төрөл ба дугаар: Худал

Тодорхойлсон нь:

Анион	1дм ³ -д байгаа			Катион	1дм ³ -д байгаа		
	мг	мг-эquiv	мг-эquiv%		мг	мг-эquiv	мг-эquiv%
Cl ⁻	9.6	0.27	9.4	Na ⁺ +K ⁺	13.8	0.60	20.9
SO ₄ ⁻	8.0	0.17	5.8	Ca ⁺⁺	29.1	1.45	50.3
NO ₂ ⁻	0.00	0.00	0.0	Mg ⁺⁺	10.1	0.83	28.8
NO ₃ ⁻	40.0	0.65	22.4	NH ₄ ⁺	0.0	0.00	0.0
CO ₃ ⁻	0.0	0.00	0.0	Fe ⁺⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	109.8	1.80	62.5	Fe ⁺⁺⁺	0.0	0.00	0.0
Дүн	167.4	2.88	100.0	Дүн	53.0	2.88	100.0

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын
нийлбэр: 165.5 мг/дм³

Анион катионуудын
нийлбэр: 220.4 мг/дм³

Ерөнхий хатуулаг 2.28 мг-эquiv/дм³
pH: 6.67

EC: 268 µS/cm
TDS: 147 ppm

Исэлдэх чанар: 0.48 мг/дм³

Физик шинж чанар

Тунгалаг: 30 см
Өнгө: өнгөлгүй

Үнэр: үгүй
Амт: ***

Тундас: Үгүй

HCO₃ 63

Усны найрлагын томъёо: M_{0.22} Ca²⁺50 Mg²⁺29 Na⁺+K⁺21

Дүгнэлт

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна. Шинжлсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь "Удмы ус, Эрүүл ажуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ МНЗ0900:2018" стандартын шаардлага хангаж байна.

Жич: Энэүү уст цэвэр сорьц авах үйл ажиллагааг зохион байгуулсан байгууллага, хувь хүн харуулан гүйцэтгэсэн болно.

Шинжилгээ Гүйцэтгэсэн: Химич, ЭШДЭА: _____ /Г. Үүрийнтуяа/

Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч _____ /Д. Гэрэлт-Од/



Хавсралт материал 5. Хөрсний шинжилгээний дүнгүүд



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/06-20/1

Захиалагч: “Миндалт констракшн” ХХК

Дээж авсан цэг: “Дэлүүн бөлдөг худалдааны тов” Хэнтий аймаг, Дадлал сум, Бани-Овоо 3-р баг

Сорьц авсан огноо: 2025 оны 06 сар 13 өдөр

Шинжилгээ хийсэн огноо: 06 сарын 20

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO ₃ , %	NO ₃ , мг/100г	Солилох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
Дээж 1											
1	0-30	7.49	0.018	0.042	1.11	0.00	0.11	10	6	3.9	9

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1								
1	0-30	6.8	69.7	10.2	6.9	2.7	3.7	13.3

3. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 1		15.0	13.9	0.0	25.7	6.4	3.5
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

*Харгалзах түвшин * Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжэнд хамаарна

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД: (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, Хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: С.ЦОЛОНГО Х.УУГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор





**“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



Монгол улс, Улаанбаатар хот, Сөнгүн Хайрхан
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/06-20/2

Захиалагч: **“Мандалт констракшн” ХХК**
Дээж авсан нэг: **“ЧХАХСЦ” төсөл, Хэнтий аймаг, Дадал сум, Баян-Овоо 3-р баг**
Сорьц авсан огноо: **2025 оны 06 сар 13 өдөр**
Шинжилгээ хийсэн огноо: **06 сарын 20**

1. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. ИГР ХӨРСӨНД

